

ХҮҮХДИЙН БӨӨРНИЙ ӨВЧЛӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД

ЭХТҮХМэргэжилтэн П.Хишгээ


ЭМГ

БӨӨРНИЙ ӨВЧЛӨЛИЙН ТУХАЙД.....

- Өнөөдөр дэлхий дээр 700 орчим сая хүн бөөрний архаг өвчтэй, эдгээр хүмүүсийн эмчилгээнд эрүүл мэндийн салбарын нийт төсвийн 80 орчим хувийг зарцуулдаг гэсэн судалгаа байдаг
- Монгол Улсын хувьд хүн амын өвчлөлийн жагсаалтаар бөөрний архаг өвчин нь сүүлийн таван жилийн дүнгээр гуравдугаар байранд, хэвтэн эмчлүүлэгсдийн шалтгаан дундаас тэргүүлэх байрыг эзэлж байна.
- Бөөр нь хос эрхтэн бөгөөд бол хүний биед ялгаруулах болон дотоод шүүрлийн гэсэн 2 чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Бөөрөөр нэг минутанд 1,2л цус эргэлдэж байдаг.
- Бөөр нь хүний биеийн бодисын солилцооны эцсийн бүтээгдэхүүнүүд, илүүдэл хорт бодисуудыг шүүн гадагшлуулж, бусад эрхтэн системийг хордохоос сэргийлдэг гол эрхтэн юм.
- Мөн хүний бие дэх ус, сахар, амин хүчил, эрдэс давсын хэмжээг тэнцвэржүүлэхээс гадна цус төлжилтөнд оролцдог.
- Бөөр нь хүний биеэр эргэлдэх янз бүрийн хортой бүтээгдэхүүнийг шүүж цэвэрлэдэг тул бөөрний үйл ажиллагаа муудахад бусад эрхтэнд үзүүлэх хор нөлөө хамгийн их байдаг.

БӨӨР ӨВЧЛӨХ ШАЛТГААН

- Шээсний замын халдвар
- Нянгаар үүсгэгдсэн шүд, гүйлсэн булчирхай, хамрын хөндийн идээт үрэвсэл
- Цаг агаарын эрс тэс байдал, хэт даарах
- Эрүүл ахуйн болон амьдралын буруу дадал зуршил
- Зөв зохисгүй хооллолт



БӨӨРНИЙ ЭМГЭГИЙН ҮЕД ИЛРЭХ ГОЛ ШИНЖ ТЭМДЭГ



Himalaya
HERBAL HEALTHCARE

БӨӨР ӨВДСӨН ҮЕД
ИЛРЭХ ШИНЖҮҮД



- ☠️ Нуруу орчим хөшиж, чилж өвдөх
- ☠️ Өглөөд нүд орчим хавагнах,
- ☠️ Шээсний өнгө өөрчлөгдөх, үнэртэй, хөөстэй болох
- ☠️ Ядрах сульдах
- ☠️ Аманд эвгүй амт амтагдах

ЦИСТОН[®] | *Бөөрөө бөндийтөл бөөцийл!*



- Толгой эргэх
- Ууц нуруу орчмоор чилж, хөшиж өвдөх
- Чих шуугих
- Хавагнах
- Шээсний өнгө, гарц, үнэр өөрчлөгдөх
- Тамирдах
- Бүсэлхий ууцаар хүйт оргих


ХҮҮХДИЙН БӨӨРНИЙ ШЭЭСНИЙ ЗАМЫН ХАЛДВАРЫН ТАРХАЛТ

- ДЭМБ-ын судалгаагаар хүүхдийн нийт өвчлөлийн дотор бөөр, шээсний замын эмгэг хоёрдугаар байранд ордог бөгөөд манай оронд амьсгалын болон хоол боловсруулах өвчлөлийн дараа гуравдугаар байранд ордог.
- Хүүхдийн бөөрний өвчний дотор цистит, пиелонефрит, бөөрний чулуу, гломерулонефрит зэрэг нь зонхилон тохиолддог.
- Бага насны хүүхдэд илүү тохиолддог шалтгаан нь түүний шээсний замын бүтцийн онцлог болох богино шээлэйтэй, халдвар эсэргүүцэх чадвар сайн хөгжөөгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн боловсрол хангалтгүйтэй холбоотой.

ХҮҮХДИЙН БӨӨРНИЙ ӨВЧЛӨЛД ХҮРГЭХ ШАЛТГААН

Хүүхдийн нас, бие махбодийн хөгжлийн онцлогтой холбоотой.

- Хүүхдийн бөөр шээсний замд бөөр шээлэй, давсаг хамаарна.
- Цуснаас бие махбодийн бодисын солилцооны үр дүнд үүссэн хэрэгцээгүй бодисыг шүүж тодорхой хугацаанд хуримтуулан шээс үүсгэдэг. Шээсний дийлэнх найрлага нь ус байдаг боловч биеэс гадагшлуулах шаардлагатай химийн нэгдлүүдийг мөн агуулна
- Бөөрөнд үүссэн шээс шээлэйгээр дамжиж давсганд очдог. Улмаар давсганд тодорхой хугацаанд хуримтлагдаж байгаад шээсний сүвээр гадагшилна.
- Шээсний сүв болон давсгаар дамжин нян орсноор шээсний замын халдвар үүсдэг. Үүсгэгч нянгууд нь шулуун гэдэснээс /хошноого/ шээсний сүв орчим салстад үржин шээсний сүвээр дамжин өгсөх халдвар үүсгэдэг. Зарим тохиолдолд нян шээсний сүв болон давсагийг үрэвсүүлдэг, гэвч халдвар давсагнаас /давсагны үрэвсэл буюу цистит/ шээлэйгээр дамжин бөөр гэмтээх /бөөрний үрэвсэл буюу пиелонефрит/ тохиолдол ч бий.
- Бага насны хөвгүүд охидоос илүү өвчилнө. Харин өсвөр насны болон насанд хүрэгчдийн дунд эмэгтэйчүүд эрчүүдээс илүү өвчилдөг.



ХҮҮХДИЙН БӨӨР ӨВДӨХӨД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ

- Бөөр шээсний замын халдварын үед олон шинжүүд илэрдэг.
- Нярай хүүхдэд их цочиромтгой болох, хөхөндөө муудах, тодорхой шалтгаангүйгээр халуурах, бөөлжих, суулгах, хүүхдийн ерөнхий байдал нь хүнд байна.

Бага насны хүүхдэд дараах шинжүүд илэрнэ.

- Халуурах хавагнах, царай цонхигор болох
- Ойр ойрхон шээх,
- Хэвлийн доод хэсгээр /давсаг/ өвдөх
- Үнэртэй/ өтгөн/ бага багаар шээх
- Зарим тохиолдолд цустай шээх эсвэл шээсний дараа цус гарах



ХҮҮХДИЙН БӨӨРНИЙ ӨВЧНИЙ ОНОШИЛГОО

- Хүүхэд бөөр шээсний замын халдвартай байж болзошгүй үед шээсийг шинжилгээнд өгөх хэрэгтэй. Шээсийг цэвэрхэн шилэнд авна. Өсвөр насны хүүхдэд шээх үедээ шээсний дунд хэсгээс цэвэр саванд авна. /замын бохирдолгүй авна/
- Шээсний ерөнхий шинжилгээ: өнгө, хувийн жин, уураг, цагаан эс, улаан эс, давс, креатинин үзнэ.
- Нян ургуулах аргаар шинжилнэ. Тусгай зориулалтын орчинд нянг өсгөвөрлөх шинжилгээ хийнэ. Энэ шинжилгээгээр үндэслэн ямар үүсгэгчтэй болох, ямар эмчилгээ хийхийг шийдэж болно.
- Үрэвсэл давсаг болон бөөрийг хамарсан байдлаас хамааран нэмэлт шинжилгээ хийх шаардлага гардаг. Хэт авиан /ЭХО/ шинжилгээ, бөөрний үйл ажиллагааны шинжилгээнүүд, изотоп шинжилгээ

ЭМЧИЛГЭЭ, ДЭГЛЭМ САХИХ

- Хоолны дэглэм: Хоол хурц биш, халуун ногоогүй бөөр, шээсний замын салстыг цочроох нөлөөгүй байх.
- Сайн унтуулж, амраах
- Шингэн хангалттай уулгах, хэвийн үеийнхээс илүү хэмжээгээр шингэн ууж, бие махбодоос шаардлагагүй хорт бодисыг гадагшлуулах
- Хэвтрийн дэглэм сахих, хөдөлгөөн хязгаарлах
- Давсаг орчим бүлээн бигнүүр тавих
- Үүсгэгчийн эсрэг, үрэвсэл намдаах зэрэг тохирсон эмийн эмчилгээг зөвхөн эмчийн заавраар хэрэглэнэ.



БӨӨРНИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Хэрхэн сэргийлэх вэ?

- Амны хөндий, шүд, гүйлсэн булчирхай үрэвсэлт өвчнөөс сэргийлэх, эмчлэх
- Шээс бэлгийн замын ариун цэврийг сахих, бүрэн эмчлэх
- Ханиад томуунаас сэргийлэх
- Даарах, норохоос сэргийлж цаг улиралд нь тохируулан хувцаслах
- Эмийг эмчийн зааврийн дагуу хэрэглэх
- Онцын шаардлагагүй бол бөөрөнд сөрөг нөлөө үзүүлэх эмийг удаан хугацаагаар хэрэглэхээс татгалзах
- Дархлааг байнга дэмжиж байх
- Шээс хүрэх бүрт шээлгэж байх



БӨӨРНИЙ ӨВЧИН ДАХИХААС ХЭРХЭН СЭРГИЙЛЭХ ВЭ?

- Хүүхэд тань бүрэн эдгэрсэн ч дахин бөөр шээсний замын халдвараар өвдөхгүй гэх баталгаа байдаггүй. Эдгэрсний дараа хүүхдэд тань дээрх шинж тэмдгүүд илэрвэл өвчин дахиж байж болох юм. Хүүхэд ямар нэг шалтгаангүйгээр халууран биеийн байдал нь муудвал эмчид яаралтай үзүүлэн шээсний шинжилгээ хийлгэх
- Бөөрний шээсний замын халдвараар өвдсөн хүүхэд бүр жилд 1-2 удаа шээсний шинжилгээ өгч байх, хэрэв өөрчлөлттэй бол эмчилгээг эмчийн заавраар давтах
- Хүйтэн сэрүүний улиралд гэлтгүй хүүхдээ даарахаас сэргийлж байх хэрэгтэй.
- Мөн хүүхэд ханиад хүрсэн бол эдгэрсний дараа нь заавал шээсний шинжилгээ өгч заншихыг эцэг эхчүүдэд захимаар байна.
- Мөн хүүхдийнхээ дотуур хувцас, ор дэрний цагаан хэрэглэлийг угааж сайтар индүүдэж өмсгөж, хэрэглүүлэх. Ялангуяа цэцэрлэг, яслийн насны хүүхдээ шөнө унтахад нь ажиглаж цагаан хорхойтой эсэхэд анхаарах. Учир нь цагаан хорхой нь давсаг, шээсний замын халдвараар өвчлөх бас нэг шалтгаан болдог



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА